



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/112

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Энхтүвшин захиралтай "Дэнж-Эрдэнэ" ХХК-ийн "Дэнж" хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Н.Батбаяр захиралтай "Сүлд хишиг" ХХК-ийн "Хишиг" хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Нямдорж захиралтай "Түмэн хунт" ХХК-ийн "Хунт" хүнсний дэлгүүр, Онгон сумын 5-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Х.Мөнхбаяр захиралтай "Агт Элбэг" ХХК-ийн "Элбэг" хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Рэгжид захиралтай "Баялагийн ундрах Баруун-Урт" ХХК-ийн "Баялагийн ундрах" хүнсний дэлгүүр, Эрдэнэцагаан сумын 2-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Нандинцэцэг захиралтай "Зотол өргөө" ХХК-ийн "Чандмань-2" хүнсний дэлгүүр, Баяндэлгэр сумын 6-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй П.Анхмаа захиралтай "Оргих цагаан булаг" ХХК-ийн "Оргих" хүнсний дэлгүүр, Баяндэлгэр сумын 6-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Эрдэнэбаатар даргатай "Баатар-Өргөө" Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн "Баатар-Өргөө" хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, Эрдэнэцагаан сумын 2-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Нандинцэцэг захиралтай "Зотол өргөө" ХХК-ийн "Чандмань-2" (зоогийн газар) үйлчилгээ, Баруун-Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Мөнхбат захиралтай "Хонгор адуут" ХХК-ийн "Nice" (Зоогийн газар) үйлчилгээний өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа буй Б.Батбаяр захиралтай "Мөнх мандал дэлгэр" ХХК-ийн "Цэлмэг" хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 3-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Э.Доржпүрэв захиралтай "Бүрэн мандах шарга" ХХК-ийн "Шарга" хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг 2022 оны

01 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (О.Балжинням), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ